

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/252/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пейж Аудит" ХХК Гүйцэтгэх захирал: С.Оюүнгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 9/05
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Г.ЦЭЦЭГМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 83,132.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

019020116

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 77,05 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>100,996,026.97</u>	<u>158,471,482.34</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	34,280,656.57	83,132,668.64
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	34,280,656.57	83,132,668.64
3121	Төгрөг	34,280,656.57	83,132,668.64
31211	Төрийн сангийн харилцах	34,280,656.57	83,132,668.64
33	АВЛАГА	413,088.70	00.00
336	Зээлийн авлага	413,088.70	00.00
3362	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	413,088.70	00.00
33621	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	413,088.70	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	66,302,281.70	75,338,813.70
351	Түүхий эд материал	46,751,437.17	54,725,337.17
35110	Тусгай зориулалттай материал	46,142,437.17	52,913,337.17
35130	Эм боох материал	609,000.00	1,812,000.00
354	Хангамжийн материал	19,550,844.53	20,613,476.53
35410	Бичиг хэргийн материал	5,289,833.60	5,821,133.60
35420	Аж ахуйн материал	13,366,653.93	13,712,553.93
35440	Түлш, шатах тослох материал	480.00	480.00
35450	Барилгын засварын материал	750,000.00	750,000.00
35460	Хүнсний материал	143,877.00	329,309.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,125,009,525.05</u>	<u>2,102,729,275.75</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,125,009,525.05	2,102,729,275.75
392	Биет хөрөнгө	2,086,761,025.05	2,064,525,775.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,095,714,500.00	2,095,714,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-156,539,622.13	-192,469,873.93
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,360,108.00	120,834,835.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-51,944,278.52	-58,298,966.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,371,997.85	85,651,997.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,308,364.89	-47,589,703.83
39214	Бусад үндсэн хөрөнгө	52,486,645.00	52,486,645.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,445,359.11	-8,373,090.29
39217	Ном	15,065,398.85	16,569,431.95
393	Биет бус хөрөнгө	38,248,500.00	38,203,500.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-157,500.00	-202,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	37,956,000.00	37,956,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,226,005,552.02</u>	<u>2,261,200,758.09</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>12,003.68</u>	<u>96,916.02</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,003.68	96,916.02

413	Өглөг	12,003.68	96,916.02
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,003.68	96,916.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,225,993,548.34	2,261,103,842.07
51	Засгийн газрын хувь оролцоо	2,225,993,548.34	2,261,103,842.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	549,972,686.96	549,972,686.96
51101	Өмч: - төрийн	549,972,686.96	549,972,686.96
512	Хуримтлагдсан үр дүн	898,293,280.33	933,403,574.06
51210	Өмнөх үеийн үр дүн	898,293,280.33	898,293,280.33
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	35,110,293.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	777,727,581.05	777,727,581.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,226,005,552.02	2,261,200,758.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,191,434,947.10	1,099,386,408.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,241,882,247.10	27,977,608.10
120	Нийтлэг татварын бус орлого	2,241,882,247.10	27,977,608.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,241,882,247.10	24,577,408.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	913,600.00	150,648.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,240,968,647.10	24,426,760.10
120009	Бусад орлого	00.00	3,400,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	295,819,700.00	1,071,408,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	823,252,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	823,252,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	653,733,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,131,600.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,131,600.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	249,688,100.00	248,156,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	249,688,100.00	248,156,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	959,089,427.65	1,064,276,114.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	959,089,427.65	1,064,276,114.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	879,591,746.89	1,037,910,842.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	474,138,637.13	566,116,156.49
210101	Үндсэн цалин	401,604,848.51	410,647,394.78
210102	Нэмэгдэл	65,404,517.45	132,756,075.70
210104	Урамшуулал	7,129,271.17	22,712,686.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,932,875.12	72,142,884.68
210201	Тэтгэврийн даатгал	41,302,165.30	49,856,376.81
210202	Тэтгэмжийн даатгал	4,806,009.10	5,758,329.81

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,817,927.16	4,553,863.81
210204	Ажилгүйдлийн даатгал	908,073.57	1,085,658.96
210205	Эрүүл мэндийн даатгал	9,098,700.00	10,888,655.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,899,025.00	249,808,573.49
210301	Гэрэл, цахилгаан	9,160,793.00	11,429,498.44
210302	Түлш, халаалт	180,538,232.00	236,202,075.05
210303	Цэвэр, бохир ус	2,200,000.00	2,177,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,001,042.36	00.00
210401	Бичиг хэрэг	684,693.36	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,316,349.00	00.00
2105	Нормативт зардал	58,623,752.20	64,511,538.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	216,534.00	00.00
210502	Хоол, хүнс	55,171,423.00	64,511,538.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,235,795.20	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,436,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	2,436,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,530,000.00	4,304,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,530,000.00	4,304,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,030,415.08	80,026,890.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,242,750.00	18,595,216.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,235,265.00	5,892,664.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,552,400.08	55,539,009.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,497,680.76	26,365,271.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,067,150.00	25,921,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,935,550.00	25,921,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,133,600.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,998,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,430,530.76	443,671.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,430,530.76	443,671.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,232,345,519.45	35,110,293.73
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,203,620.31	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,203,620.31	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,203,620.31	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,227,141,899.14	35,110,293.73

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	950,466,300.00	1,074,959,648.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	913,600.00	3,550,848.00
120	Нийтлэг татварын бус орлого	913,600.00	3,550,848.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	913,600.00	150,648.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	913,600.00	150,648.00
120009	Бусад орлого	00.00	3,400,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	949,552,700.00	1,071,408,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	823,252,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	823,252,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	653,733,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,131,600.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,131,600.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	249,688,100.00	248,156,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	249,688,100.00	248,156,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	898,194,643.43	1,026,107,635.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	898,194,643.43	1,026,107,635.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	818,564,512.67	999,612,164.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	474,551,725.91	565,703,067.79
210101	Үндсэн цалин	343,324,457.97	409,166,512.05
210102	Нэмэгдэл	107,685,708.27	134,327,470.96
210104	Урамшуулал	23,541,559.67	22,209,084.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,920,871.36	72,057,972.34
210201	Тэтгэврийн даатгал	41,239,569.91	49,531,762.31
210202	Тэтгэмжийн даатгал	4,834,407.26	5,765,841.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,823,845.67	4,550,121.22
210204	Ажилгүйдлийн даатгал	909,552.99	1,102,623.17
210205	Эрүүл мэндийн даатгал	9,113,495.53	11,107,623.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,899,025.00	246,712,728.32
210301	Гэрэл, цахилгаан	9,160,793.00	8,333,653.27
210302	Түлш, халаалт	180,538,232.00	236,202,075.05
210303	Цэвэр, бохир ус	2,200,000.00	2,177,000.00
2105	Нормативт зардал	55,770,375.40	64,486,770.00
210502	Хоол, хүнс	55,770,375.40	64,486,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,996,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	13,996,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,530,000.00	4,836,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	531,300.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,530,000.00	4,304,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,896,515.00	44,815,525.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,999,800.00	38,344,861.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,896,715.00	6,470,664.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,630,130.76	26,495,471.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,199,600.00	26,051,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,068,000.00	26,051,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,133,600.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,998,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,430,530.76	443,671.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,430,530.76	443,671.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>52,271,656.57</u>	<u>48,852,012.07</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,991,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,991,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,991,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,991,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-17,991,000.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	34,280,656.57	48,852,012.07
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	34,280,656.57
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,280,656.57	83,132,668.64

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	549,972,686.96	778,096,917.25	898,293,280.33	2,226,362,884.54
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	549,972,686.96	778,096,917.25	898,293,280.33	2,226,362,884.54
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	549,972,686.96	778,096,917.25	898,293,280.33	2,226,362,884.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	549,972,686.96	778,096,917.25	898,293,280.33	2,226,362,884.54
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	35,553,965.41	35,553,965.41
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	549,972,686.96	778,096,917.25	933,847,245.74	2,261,916,849.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	866,291,400.00	777,951,235.93	88,340,164.07	89.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	866,291,400.00	777,951,235.93	88,340,164.07	89.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	832,532,300.00	751,899,435.93	80,632,864.07	90.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	626,365,500.00	565,703,067.79	60,662,432.21	90.32
210101	Үндсэн цалин	434,105,900.00	409,166,512.05	24,939,387.95	94.25
210102	Нэмэгдэл	170,477,800.00	134,327,470.96	36,150,329.04	78.79
210104	Урамшуулал	21,781,800.00	22,209,084.78	(427,284.78)	101.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,295,500.00	72,057,972.34	6,237,527.66	92.03
210201	Тэтгэврийн даатгал	53,241,000.00	49,531,762.31	3,709,237.69	93.03
210202	Тэтгэмжийн даатгал	6,263,700.00	5,765,841.98	497,858.02	92.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,010,800.00	4,550,121.22	460,678.78	90.81
210204	Ажилгүйдлийн даатгал	1,252,700.00	1,102,623.17	150,076.83	88.02
210205	Эрүүл мэндийн даатгал	12,527,300.00	11,107,623.66	1,419,676.34	88.67

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,400,200.00	-	3,400,200.00	-
210301	Гэрэл, цахилгаан	3,400,200.00	-	3,400,200.00	-
2105	Нормативт зардал	72,488,100.00	64,486,770.00	8,001,330.00	88.96
210502	Хоол, хүнс	72,488,100.00	64,486,770.00	8,001,330.00	88.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,063,400.00	4,836,100.00	2,227,300.00	68.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,740,800.00	531,300.00	2,209,500.00	19.38
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,322,600.00	4,304,800.00	17,800.00	99.59
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,919,600.00	44,815,525.80	104,074.20	99.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,435,700.00	38,344,861.80	90,838.20	99.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,483,900.00	6,470,664.00	13,236.00	99.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,759,100.00	26,051,800.00	7,707,300.00	77.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,759,100.00	26,051,800.00	7,707,300.00	77.17
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,759,100.00	26,051,800.00	7,707,300.00	77.17
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	852,380,100.00	823,403,048.00	28,977,052.00	96.60
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	850,552,900.00	823,252,400.00	27,300,500.00	96.79
131001	Улсын төсвөөс санхүүжих	850,552,900.00	823,252,400.00	27,300,500.00	96.79
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,827,200.00	150,648.00	1,676,552.00	8.24
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,827,200.00	-	1,827,200.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	150,648.00	(150,648.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	34,280,656.57	(34,280,656.57)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	34,280,656.57	(34,280,656.57)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	38.00	38.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	24.00	24.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургууль нь Монгол Улсын боловсролын ерөнхий хуулийн дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг. 2023-2024 оны хичээлийн жилд хамтын оролцоонд суурилсан сургуулийн менежментийг сайжруулах жил болгон үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна. Үүний хүрээнд сургуулийн үйл ажиллагаанд нэгдсэн дүгнэлт хийж сургалтын чанарыг сайжруулахыг эрхэм зорилго болгож ажиллаж байна.

Алсын хараа

Асуудлыг шинжлэх ухаанч арга барилаар шийдвэрлэдэг, Өөрийгөө тасралтгүй хөгжүүлдэг иргэнийг бэлтгэх

Зорилт

- ✓ Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулийг сургалтын байгууллага бүрийн багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийтэд сурталчлан таниулах, тэдний оролцоотой үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор "Хуулиа хэрэгжүүлэе" аяныг зохион байгуулах
- ✓ Малчин болон алслагдсан бүс нутагт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт, үйл ажиллагаагаар дэмжих, сургуульд элсэн суралцсан 6 настанд дасан зохицох бэлтгэл хангах
- ✓ Тэгш хүртээмжтэй, тэгш боломж олгосон, хамтын хариуцлагатай байх суурь зарчимд тулгуурлан байршлаас хамаарсан үйлчилгээний чанарын ялгааг бууруулж хүүхэд бүр гэртээ ойр байрлах цэцэрлэг, сургуульд хамрагдах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэх
- ✓ Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах
- ✓ Суралцагчийн математик, англи хэлний сургалтыг дэмжих цахим технологи (сургалтын платформ)-д суурилсан нэмэлт хөтөлбөрийг бага, суурь боловсролын зарим ангид хэрэгжүүлж, суралцагчийн үр чадвар багшийн арга зүйд ахиц гаргах
- ✓ Суралцагчдын шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх нэгдмэл агуулга бүхий төсөлт ажлыг анги, бүлгээс үл хамааран багаар хамтран гүйцэтгүүлж үр дүнг хагас жил бүр тооцох
- ✓ Суралцахуй болон судлагдахуунд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг дэмжиж, ажлын гүйцэтгэл, үр дүнд шинжилгээ хийх, багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системийг ашиглах замаар багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх үр чадварт гарсан ахиц, өөрчлөлт, үр дүнг тооцох
- ✓ Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах, тэгш боломж олгох орчныг сургалтын байгууллага бүр төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн дэмжлэгтэйгээр бүрдүүлж, дэмжлэгийн багийн үйл ажиллагааг сайжруулах замаар тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх
- ✓ Мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагч бүрийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран MEDLE.mn сургалтын үндэсний нэгдсэн платформыг ашиглан суралцах тэгш боломж бүрдүүлэх
- ✓ Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагын дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өндөрширээт сумын сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Сургууль нь сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, мэдлэг чадвар авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг эх асран хамгаалагч, дэмжигчтэй хамтран ажиллах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Боловсролын ерөнхий хууль шинэчилсэн найруулга
- ✓ Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль
- ✓ Зөвшөөрлийн тухай хууль
- ✓ Багшийн хөгжлийг дэмжих тухай
- ✓ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамрах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор цалингийн доод хэмжээг тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу бүрэн ирүүлсэн.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,195.2 мянган төгрөгөөр бууу 1.59 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	34,280.66	83,132.67	48,852.01
Авлага	413.09		(413.09)
Урьдчилгаа			-
Бараа материал	66,302.28	75,338.81	9,036.53
Үндсэн хөрөнгө	2,125,009.53	2,102,729.28	(22,280.25)
Нийт хөрөнгө	2,226,005.55	2,261,200.76	35,195.21
Өр төлбөр	12.0	96.9	84.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	549,972.69	549,972.69	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,226,005.55	2,261,200.76	35,195.21

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өглөг, үндсэн хөрөнгийн данс байна. Үүнд:

Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 83,132.6 мянган төгрөгөөр харагдаж байгаа нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

Авлагын дансны 431.1 төгрөгийг залруулга хийсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материал өмнөх оноос 22,280.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 115,867.7 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 106,831.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 22,280.3 мянган төгрөгөөр буурсан нь нэмэгдсэн хөрөнгө нь элэгдлийн дүнгээс бага байгаа нь нөлөөлсөн байна.

Өглөгийн данс 84.9 төгрөгөөр нэмэгдсэн нь хүмүүст өгөх татварын өглөгөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 564,126.8 мянган төгрөг, нийт зарлагыг 564,126.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 286,426.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 850,552.9 зардлыг мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төв аймгийн Өндөрширээт сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийн захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 27,300.5 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 823,252.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 150.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 777,951.2 мянган төгрөг буюу 89.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 88,340.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80226-байр ашиглах үйлчилгээ	1,729.0	1,729.0	-	100
2	80321-сургалт семинар	864.5	864.5	-	100
3	81605-эрүүл мэндийг дэмжих	1,729.0	1,729.0	-	100
4	81801-үдийн цай хөтөлбөр	33,759.1	26,051.8	7,707.3	78
5	81806-дотуур байрны үйлчилгээ	103,761.9	89,404.6	14,357.3	86
6	81816-хүүхдэд ээлтэй сургалтын орчин	17,839.0	17,676.0	72.0	99
7	81823-боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	3,890.3	3,890.3	-	100
8	81827-бичиг үсгийн боловсрол хөтөлбөр	3,220.0	1,699.8	1,520.1	52
9	81834-боловсролын стандарт% сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	498,471.1	469,835.9	28,635.2	95
10	81835-сургалтын хэвийн үйл ажиллагаа	158,732.3	132,404.7	26,327.6	84
11	81844-гүнзгий болон төрөлжсөн	3,550.9	3,549.8	1.0	99
12	81848-сурах бичгийн түрээс	913.6	531.3	382.3	59
	дүн	828,460.7	749,366.7	79,002.8	89.8
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
1	80111-төрийн өмчит барилгын тогтмол зардал	248,156.4	247,712.7	443.6	99.8
	дүн	248,156.4	247,712.7	443.6	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Я.Оюун, Шинжээч Х.Ариунжаргал, Ц.Цацрал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 3,3191,434.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 47,871.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 35,903.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, байгаа хэдий ч байгалийн цаг уурын өөрчлөлт цаг зудын эрсдэлтэй үед хэмнэлтийн хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.4.1.1 Тайлант хугацаанд шилэн дансанд нийт 144 мэдээ мэдээллээс 143 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 1 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй 93,826.2 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.4."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь. Хууль тогтоомж, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээнд дээр хөрөнгийн хэмжээ 229,430.1 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 549,972.7 мянган төгрөг засгийн газрын оролцоо сан 320,542.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийг үнэн зөв баталгаажуулах, бүртгэлдээ өөрчлөлтийг оруулдаг байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, Засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт, өглөгийн данстай холбоотой нийт 7 зөвлөмж хүргүүлснээс 4 зөвлөмж хэрэгжүүлэн ажилласан, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,175.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 2 зөвлөмжийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	7,175.7	3	7,175.7	100.0
Зөвлөмж	2		2		100.0
Нийт дүн	5	7,175.7	5	7,175.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал төсөв, санхүүжилтийг үндэслэлтэй баталдаг байх, шинэчлэлийн бодлого, төрийн чиг үүргийг хангалттай хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар анхаарал хандуулах болно. Сургуулийн газар эзэмших эрхтэй холбоотой асуудлыг хянаж үзэх, газрын ашиглалт, баталгаажуулалт, сайжруулалт, төлбөр төлөлтийн талаар дараагийн аудитаар авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 33,596.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 14.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, дахин давтахгүй байх 33,581.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

1. Татварын цахим тайлангийн системээр газрын төлбөр 14.5 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах, аудитын батламж мэдэгдлийн оршин байх "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж байгууллагад бодитой оршин байх", эрх ба үүрэг "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өглөг уг аж ахуй нэгж байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх" гэсэн батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь. Хууль тогтоомж, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 33,581.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим баримтын бүрдэлгүй гүйлгээ гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 20 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Газрын төлбөр 14.5 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байна.	1	14.5			1	14.5						
Цахим баримт 33,581.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	1	33,581.5					1	33,581.5				
Дүн	2	33,596.0			1	14.5	1	33,581.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцорсон 1 мэдээлэл, 93,826.2 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байна.	1	93,826.2			1	93,286.2		
Дүн	1	93,826.2			1	93,286.2		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засгийн газрын оролцоо сан 320,542.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	320,542.6					1	320,542.6
Дүн	1	320,542.6					1	320,542.6
Нийт дүн	2	418,868.8			1	93,286.2	1	320,542.6



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 19-14570516-ТӨА-2024/

Зуунмод

1050/КА-СТА-ТМС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өндөрширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 93,826,200 /ерэн гурван сая найман зуун хорин зургаан мянга хоёр зуун/ төгрөг өссөн дүнгээр зөрүүтэй мэдээлсэн, хугацаа хоцорсон 1 мэдээлэл байршуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх";, 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040088

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 77,05 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ